

Солонгост оршин суугаа гадаадын иргэн COVID-19 халдварын эсрэг вакцинд хэрхэн хамрагдах тухай заавар

Солонгост оршин сууж буй гадаад иргэн нь Солонгос иргэний нэгэн адил жишиг зааварын дагуу урьдчилсан захиалгад хамрагдах болно. Доорх вакцинд хамрагдах хүн болон урьдчилсан захиалга хийх аргын талаарх заавартай танилцан COVID-19 вирусийн эсрэг вакцинуулахын захиалгаа өгнөүү.

□ Вакцинд хамрагдах хүн болон урьдчилсан захиалга хийх арга

◦ Гадаадын иргэний бүртгэлтэй гадаад иргэн

- '8~9 сарын вакцинжуулалтын төлөвлөгөөний дагуу' дэс дараалалтайгаар вакцинжуулалтын захиалга хийх ба захиалгыг онлайн аар болон утсаар ярьж хийх боломжтой.

* Онлайн аар захиалга хийх үед 'захиалганд хамрагдах хүн биш байна' гэж гарч ирвэл харьяа эрүүл мэндийн төвд очиж бүртгүүлсний дараа захиалга хийх боломжтой.

- Урьдчилсан захиалга хийх арга-

◦ (Онлайн захиалга хийх - **хувь хүн өөрөө болон өөр хүн төлөөлөн хийх боломжтой**) COVID-19 вирусийн эсрэг урьдчилсан захиалгын систем (<http://ncvr2.kdca.go.kr>) т нэвтрэн орж захиалга өгөх (**Таныг төлөөлөн хэн нэгэн захиалга хийх боломжтой**)

◦ (Утсаар ярьж захиалга хийх - өөрөө эсвэл өөр хүн төлөөлөн хийх боломжтой) Халдварт өвчин судлалын газрын дуудлагын төв (1339) эсвэл COVID-19 вирусийн эсрэг урьдчилсан захиалгын систем (Вакцинжуулалтанд хамрагдсан байдал (хулганаа тавих) → COVID-19 эсрэг вакцинжуулалтын утсаар захиалга хийх байгууллагын байдал гэсэн хэсэгт дарах) ээс орон нутгийн засаг захиргааны захиалгын талаар зөвлөгөө авах утасыг шалгах

◦ Гадаадын иргэний бүртгэлийн дугаар (үнэмлэх) гүй гадаадын иргэн (хууль бусаар оршин сууж буй гадаад иргэн)

- Эрүүл мэндийн төвд очиж гадаад паспортаар түр хяналтын дугаар авах ба вакцинжуулалтын захиалга хийх боломжтой.

* Гадаад паспортын хүчинтэй хугацаа нь дууссан гадаадын иргэн нь хүчинтэй хугацаа нь дууссан паспорт, оршин суух хугацаа нь дууссан гадаад иргэний үнэмлэх, Солонгос дахь элчин сайдын яамнаас авсан биеийн байцаалт зэргийг бэлдэж очих

- Ажил олгогч нь гадаад ажилчны хувийн мэдээлэл (нэр, төрсөн огноо, хүйс, иргэншил, оршин суух хаяг, ажлын байрны хаяг) зэрэг мэдээлэлээр түр хяналтыг дугаарыг авах боломжтой.

- Түр хяналтын дугаар авсны дараа онлайн болон утсаар вакцины захиалга хийх боломжтой. (таныг төлөөлж хэн нэгэн захиалга хийх боломжтой)

※ Аялал жуулчлалын зорилгоор Солонгост ирээд байгаа 90 хоногоос доош богино хугацааны оршин суугчид хамрагдахгүй.

□ Анхаарах зүйл

◦ Хувийн мэдээллийг зөвхөн вакцинжуулалтад хамруулах зорилгоор ашиглах, бөгөөд мэдэгдэх үүргээс чөлөөлөх журмын дагуу цагаачлалын албанд хууль бус оршин суугч болохыг мэдээлэхгүй болно.

◦ Тарилгад хамрагдах газар нь тухайн хүн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эсэхээс хамаарч хязгаарлалт байж болно.

◦ Эрүүл мэндийн даатгалгүй иргэд нь эрүүл мэндийн төв болон вакцинжуулалтын төв дээр вакцин тариулах

* Эмнэлэг · эрүүл мэндийн байгууллагад дээр вакцин тариулах боломжгүй.

<Энэ орчуулгыг Данури төв 1577-1366 хийсэн болно>